

1. ХЭРЭГЛЭГЧДИЙН ИНФЛЯЦИЙН ХҮЛЭЭЛТИЙН ТҮҮВЭР СУДАЛГААНЫ ДҮН

Иргэдийн түүвэр судалгаанд Улаанбаатар хотын 9 дүүргийн 135 хорооноос 1030 өрхийг санамсаргүйгээр сонголоо. Судалгааны дүнгээр иргэдийн хүлээгдэж буй инфляцийн түвшин 2011 оны 2-р улирлын эцэст 11.4%, дараа жилийн 1-р улирлын эцэст 12.0% байна.

1.1. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл

- Нийт судалгаанд оролцогчдын дийлэнх /65.7%/ нь эмэгтэй;
- Насны бүтцийг харвал судалгаанд оролцогчдын ихэнх /60.9%/ нь 25-54 насны иргэд байгаа нь худалдан авах шийдвэрээ бие даан гаргах чадвартай, үнийн өсөлтийн талаар мэдээлэл сайтай байх магадлалтай юм;
- Боловсролын түвшинг харахад дийлэнх /88.4%/ нь бүрэн дунд болон дээд боловсролтой;
- Ам бүлийн тоог харвал нийт судалгаанд оролцогчдын 80.7% нь 2-5 ам бүлтэй;
- Ажил эрхлэлтийн байдлыг харвал ихэнх /49.7%/ нь хувийн салбарт ажилладаг, мөн 14.5% нь төрийн албанд, 26.6% нь ажилгүй;
- Өрхийн орлогыг харвал 59.7% нь 400 мянгаас доош төгрөгийн орлоготой бөгөөд үүний тал нь 200 мянгаас бага, 32.5% нь 400-800 мянга, 7.8% нь 800 мянгаас дээш орлоготой өрхүүд байлаа.¹

Хүснэгт 1.1 Үнийн хүлээлтийн чанарын хариулт /ирэх 12 сарын хугацаанд/

	2008 оны	2009 оны	2010 оны	2010 оны	2011 оны	2011 оны 3
	12 сар	9 сар	1 сар	7 сар	1 сар	сар
	Хувиар	Хувиар	Хувиар	Хувиар	Хувиар	Тоо Хувиар
1. Үнэ өснө, гэхдээ илүү хурдацтай өснө	23.2%	25.3%	30.7%	21.6%	43.5%	334 32.4%
2. Үнэ өснө, гэхдээ өсөлтийн хурдац өөрчлөгдөхгүй	24.6%	32.2%	39.0%	38.8%	24.2%	354 34.4%
3. Үнэ өснө, гэхдээ өсөлтийн хурдац буурна	19.4%	16.6%	10.0%	18.5%	11.4%	109 10.6%
4. Үнэ өөрчлөгдөхгүй	9.6%	4.1%	3.1%	5.0%	4.4%	36 3.5%
5. Үнэ буурна	4.6%	1.4%	0.5%	0.7%	1.2%	27 2.6%
6. Мэдэхгүй	18.6%	20.4%	16.7%	15.4%	15.3%	170 16.5%
Нийт	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%	1030 100.0%

Эх сурвалж: Монголбанк

Хүснэгт 1.2 Үнийн хүлээлтийн чанарын хариулт /ирэх 3 сарын хугацаанд/

	2011 оны 1 сар		2011 оны 3 сар	
	Тоо	Хувиар	Тоо	Хувиар
1. Үнэ өснө, гэхдээ илүү хурдацтай өснө	446	44%	311	30.2%
2. Үнэ өснө, гэхдээ өсөлтийн хурдац өөрчлөгдөхгүй	280	28%	363	35.2%
3. Үнэ өснө, гэхдээ өсөлтийн хурдац буурна	93	9%	125	12.1%
4. Үнэ өөрчлөгдөхгүй	48	5%	56	5.4%
5. Үнэ буурна	11	1%	23	2.2%
6. Мэдэхгүй	128	13%	152	14.8%
Нийт	1006	100%	1030	100.0%

Эх сурвалж: Монголбанк

1.2. Хүлээлтийн түвшин /чанарын хариулт/


Иргэдийн 77% нь ирэх 12 сарын хугацаанд үнийн түвшин ерөнхийдөө өснө гэж үзэж байна. Үүнээс ойролцоогоор 32% нь одоогийн инфляцийн түвшнээс илүү хурдацтайгаар, 34% нь одоогийнхтой адил түвшинд, 11% нь одоогийнхоос бага хэмжээгээр өснө гэжээ. Харин 3% нь үнэ өөрчлөгдөхгүй, 2% нь буурна гэжээ /Хүснэгт 1.1/.

Харин иргэдийн 78% нь ирэх 3 сарын хугацаанд үнийн түвшин ерөнхийдөө өснө гэж үзэж байна. Үүнээс ойролцоогоор 30% нь одоогийн инфляцийн түвшнээс илүү хурдацтайгаар, 35% нь одоогийнхтой адил түвшинд, 12% нь одоогийнхоос бага хэмжээгээр өснө гэж үзжээ /Хүснэгт 1.2/.

Өмнөх судалгааны дүнгээс харахад иргэдийн ихэнх нь үнэ одоогийнхоос хурдацтайгаар өснө гэж үзсэн бол энэ удаагийнхад энэ хариултын түвшин нэлээдгүй буурсан нь

¹ Дэлгэрэнгүй мэдээллийг хавсралт 1 – ээс харна уу.

Зураг 1.1 Жилийн хүлээлт ба инфляцийн түвшин



Эх сурвалж: Монголбанк

иргэдийн инфляцийн хүлээлт бага зэрэг буурсныг харуулж байна.


Дээрх чанарын хариултуудыг Карлсон-Паркин нарын магадлалын аргаар² тоон утгад хөрвүүлэн тооцвол иргэд 2-р улирлын эцэст жилийн инфляци **11.4%**, дараа оны 1-р улирлын эцэст **12.0%**-д хүрнэ гэж хүлээж байна. /Зураг 1.1/-ээс харахад өмнөх судалгааны дүнгээр иргэдийн ирэх 12 сарын хүлээлт инфляциас нилээд дээгүүр болж, өсөх хандлага ажиглагдаж байсан бол энэ удаагийнхаар инфляцийн түвшинг даган багасч, буурах хандлагатай байна.

Шигтгээ 1.1. Эдийн засаг сэргэж байгаа ч инфляци хурдацтай өсч болзошгүй

Ашигт малтмалын экспортын их өсөлт, хувийн секторын үйл ажиллагааны идэвхжилт ба төсвийн хүчтэй тэлэлтээс шалтгаалан Монгол улсын эдийн засаг сэргэлтийн байдалдаа орж 2011 онд дээд тал нь 10 хувиар өсөх таамаглалтай байна. Энэ нь нэгэнт инфляци өндөр түвшинд очсон эдийн засгийг хэт халааж оны эцсээр инфляци 20%-д хүрч болзошгүй юм. Төсвийн хэт тэлэлт нь эдийн засагт сайнаасаа илүү муу үр дагаврыг дагуулах эрсдэлтэй байна. Засгийн газрын зардал нь ашигт малтмалын бус эдийн засгийн бараг 2/3-т хүрсэн бөгөөд зардлын 35 хувийн энэ өсөлт нь дотоодын үйлдвэрлэлийн хүчин чадлаас хэт давсан эрэлтийг бий болгож байгаа юм. Үүний үр дүнд инфляци жолоогоо алдаж, бодит ханшны чангаралтыг хурдасгаж хувийн секторыг хохироох болно. Олон улсын туршлага иймэрхүү өндөр инфляци, ялангуяа үндсэн хоол хүнсний үнийн өсөлт нь ядуучуудад хүчтэй нөлөөлдгийг өмнө нь харуулсан билээ. Хэрэв төсвийн хэт тэлэлт зогсохгүй бол Төв Банк инфляциас урьдчилан сэргийлэх алхмуудыг авч, хүүг өсгөж мөнгөний хумих бодлогыг даруй эхлүүлэх нь зүйтэй. Учир нь бодлогын хүү бодит түвшинд аль хэдийнэ хасах болсон бөгөөд инфляци өсвөл улам нэмэгдэх болно.

Эх үүсвэр: Олон улсын валютын сан / Country Report №11/24, 2011 оны 2-р сар/

Зураг 1.2 Иргэдийн инфляцийн хүлээлт /ирэх 12 сарын хугацаанд/



Эх сурвалж: Монголбанк

1.3. Хүлээлтийн түвшин /тоон хариулт/

Иргэдийн 12 сарын дараах хүлээлтийн түвшинг мөн тодорхой тоон завсраас асуух замаар тооцоолол хийлээ. /Зураг 1.2/ –оос харахад иргэдийн хамгийн их /26%/ нь инфляцийг 13-15%-д, дараа /18%/ нь 11-13%-д, мөн /16%/ 9-11%-д байна гэж үзжээ. Мөн зургаас иргэдийн хүлээлт энгийн тархалттай харагдаж байгаа бөгөөд дундаж утгыг олбол **11.9%** байна.

Шигтгээ 1.2. Үнийн өсөлтийн дарамт нэмэгдэж байна

Сүүлийн саруудад инфляци хоёр оронтой тоонд хадгалагдаж, илүү өргөн хүрээг хамарч байна. Энэ жилийн их хэмжээний төсвийн зардлын тэлэлт, өнгөрсөн оны 30 хувийн цалингийн өсөлт зэргээс шалтгаалан эрэлт хүчтэй нэмэгдсэнээс цаашид үнэ өсөх дарамт үргэлжлэх төлөвтэй байна. Үүний зэрэгцээ Хятад болон дэлхий дахины хүнсний үнийн өсөлт, зээлийн дахин сэргэлт, уул уурхайн салбарын хурдтай хөгжил нь үнийн өсөлтийн дарамтыг улам нэмэгдүүлж байна. ОУВС-ийн судлаачид хэрвээ төсвийн зардал хумигдахгүй бол оны эцэст инфляци 20 хувь байхаар тооцоолж байна. Эрх баригчид инфляци ингэж хурдацтай өсөх нь нийгэм, эдийн засагт ялангуяа ядуучуудад маш хүндээр тусна гэдгийг онцолж байгаа ч Төв Банк төсвийн тэлэлтийг тэнцвэржүүлэх мөнгөний бодлогод хязгаар байгааг бас анхааруулж байгаа юм.

Эх үүсвэр: Олон улсын валютын сан /Country Report №11/76, 2011 оны 3-р сар/

² Carlson, John A. and Parkin, Michael /1975/: Inflation expectations. "Economica" 42, pp. 123-38.

Хүснэгт 1.3 Таны бодлоор ирэх 12 сарын хугацаанд банкны зээлийн хүү хэрхэн өөрчлөгдөх вэ?

	2011 он 1 сар	2011 он 3 сар	Өөрчлөлт
Өснө	18.0	19.3	1.3
Хэвэндээ байна	32.5	28.4	-4.1
Буурна	17.9	23.0	5.1
Мэдэхгүй	31.6	29.2	-2.4
Нийт	100.0	100.0	-

Эх сурвалж: Монголбанк

Хүснэгт 1.4 Таны бодлоор ирэх 12 сард төгрөгийн ханш хэрхэн өөрчлөгдөх вэ?

	2011 он 1 сар	2011 он 3 сар	Өөрчлөлт
Чангарна	35.7	33.4	-2.3
Хэвэндээ байна	45.2	40.7	-4.5
Суларна	19.1	25.9	6.8
Нийт	100.0	100.0	-

Эх сурвалж: Монголбанк

Хүснэгт 1.5 Таны бодлоор ирэх 12 сард хадгаламжинд мөнгө хийхэд тохиромжтой үе мөн үү?

	2011 он 1 сар	2011 он 3 сар	Өөрчлөлт
Тийм	22.7	24.0	1.3
Үгүй	26.5	24.4	-2.2
Мэдэхгүй	50.8	51.7	0.9
Нийт	100.0	100.0	-

Эх сурвалж: Монголбанк

1.4. Бусад асуултуудын дүн

Иргэдийн 19% нь **зээлийн хүү өснө** гэж хариулсан нь өмнөх судалгааны дүнгээс 1.3 нэгжээр өссөн бол хэвэндээ байна гэсэн нь 4 нэгжээр буурч харин зээлийн хүү буурна гэж иргэдийн бараг 4 ний нэг нь хариулж өмнөхөөс 5 нэгжээр өсчээ. Зээлийн нэрлэсэн хүү нь инфляци болон бодит хүүнээс бүрдэнэ. 2009 оны эцэст инфляци тогворжиж нам түвшинд очсон ч 2010 оны эцэст хоёр оронтой тоонд хүрсэн. Энэ нь зээлийн хүүг бууруулахгүй байх нэг шалтгаан нь гэж хэлж болхоор байна.

Иргэдийн 4 ний нэг нь төгрөгийн **ханш суларна** гэж хариулсан нь өмнөх дүнгээс 7 нэгжээр өсч харин **чангарна** гэсэн хариулт 2 нэгжээр, хэвэндээ байна гэсэн нь 4 нэгжээр буурсан байна. Сүүлийн жил Монгол улсад орох хөрөнгийн урсгал улам эрчимжиж байгаагаас шалтгаалан ам.доллартай харьцах төгрөгийн ханш аажмаар чангарсаар хямралын өмнөх үеийн түвшинд хүрсэн. 2011 оны 3-р сарын дундаж ханш өмнөх сартай харьцуулахад 2 хувиар, 2010 оны 3-р сартай харьцуулахад 13 хувиар тус тус чангарсан байна.

Судалгаанд оролцогчдын 24 гаруй хувь нь **хадгаламжид мөнгө хийхэд тохиромжтой** гэж үзэж байгаа бөгөөд тохиромжгүй гэсэн хариулт 2 нэгжээр буурч 24%-д хүрчээ. Хадгаламжийн бодит хүү сөрөг³ байгаа ч хадгаламжийн баталгааны хууль болон ханшийн чангаралтаар өдөөгдсөн төгрөгийн хадгаламж өсөх⁴ хандлага үргэлжилсээр байна. Гэвч ам.долларын хадгаламжийн хүү маш өндөр байгаа нь /хугацаатай хадгаламжийн хүү 14 хүртэл хувьтай/ зах зээлийн эрсдэлтэй байдлыг харуулж байгаа бөгөөд хувийн салбарын гадаадаас зээл авах явдал нэлээд их хэмжээгээр нэмэгдлээ. Хэрэв зээлдүүлэгч мөнгөө гэнэт татсан тохиолдолд

³ 2011 оны 2 сарын эцсийн байдлаар хадгаламжийн жигнэсэн дундаж хүүнээс инфляцийн түвшинг хасаж тооцсон бодит хүү - 0.3 % байна.

⁴ 2011 оны 2 сарын эцсийн байдлаар төгрөгийн хадгаламж жилийн 69 хувийн өсөлттэй байна.

Хүснэгт 1.6 Танай өрхийн санхүүгийн байдал ирэх 12 сарын хугацаанд хэрхэн өөрчлөгдөх вэ?

	2011 он 1 сар	2011 он 3 сар	Өөрчлөлт
Сайжирна	22.5	21.6	-0.9
Хэвэндээ байна	37.9	42.8	4.9
Муудна	15.9	13.2	-2.7
Мэдэхгүй	23.8	22.4	-1.3
Нийт	100.0	100.0	-

Эх сурвалж: Монголбанк

Хүснэгт 1.7 Хэрэв сайжрах бол шалтгаан нь юу вэ?

	2011 он 1 сар	2011 он 3 сар	Өөрчлөлт
Цалин нэмэгдэнэ	19.8	22.4	2.5
Бизнесийн орлого нэмэгдэнэ	22.3	21.7	-0.6
Үл хөдлөх хөрөнгийн үнэ өснө	10.2	15.3	5.1
Өрхийн гишүүн ажлын байртай болно	20.1	24.7	4.6
Үнэ буурна	4.8	3.7	-1.2
Төрөөс тэтгэмж, тэтгэлэг авна	12.1	6.2	-5.9
Хамаатан, найз нараас тусламж авна	1.9	.9	-1.0
Татварын хөнгөлөлт чөлөөлөлт хүртэнэ	8.8	5.3	-3.6
Нийт	100.0	100.0	-

Эх сурвалж: Монголбанк

Хүснэгт 1.8 Хэрэв муудах бол шалтгаан нь юу вэ?

	2011 он 1 сар	2011 он 3 сар	Өөрчлөлт
Цалин буурна	8.0	16.7	8.7
Бизнесийн орлого буурна	16.8	13.0	-3.8
Үл хөдлөх хөрөнгийн үнэ буурна	8.0	7.9	-0.1
Өрхийн гишүүн ажилгүй болно	16.4	13.0	-3.4
Үнэ өснө	37.6	32.6	-5.0
Төрөөс тэтгэмж, тэтгэлэг авахгүй	3.6	5.0	1.4
Бусад санхүүгийн тусламж үзүүлнэ	3.6	3.3	-0.3
Татварын ачаалал ихэснэ	6.0	8.4	2.4
Нийт	100.0	100.0	-

Эх сурвалж: Монголбанк

зээлдэгчийг эмзэг байдалд оруулж болзошгүй юм.

Иргэдийн өрхийн **санхүүгийн байдал муудна** гэсэн хариулт өмнөхөөс 3 нэгжээр буурсан бол хэвэндээ байна гэсэн нь 5 нэгжээр харин сайжирна гэсэн хариулт бараг өөрчлөлтгүй байна. Мэдэхгүй гэсэн хариултын дүн бага зэрэг буурсан байна.

Сайжирна гэж судалгаанд оролцсон иргэдийн 21.6% нь хариулсан бөгөөд давхардсан тоогоор тэдгээрийн ихэнх нь ирэх 12 сард цалин нэмэгдэнэ, бизнесийн орлого нэмэгдэнэ, ажлын байртай болно гэсэн хариултаудыг өгсөн байна. Өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад Үл хөдлөх хөрөнгийн үнэ өснө гэсэн хариулт 5 нэгжээр, ажлын байр бий болно гэсэн нь 4 нэгжээр, цалин нэмэгдэнэ гэсэн хариулт 2 нэгжээр өссөн бол төрөөс тэтгэлэг авна гэсэн хариулт 6 нэгжээр, татвара хөнгөлөгдөнө гэсэн нь 4 нэгжээр тус тус буурсан байна.

Муудна гэж иргэдийн 13% нь хариулсан бөгөөд давхардсан тоогоор тэдгээрийн ихэнх нь үнэ өссөнөөс, цалин болон бизнесийн орлого буурснаас, ажлын байргүй болсноос болж муудна гэж үзжээ. Өмнөх судалгааны дүнтэй харьцуулбал цалин буурна гэсэн хариулт 9 нэгжээр, татварын ачаалал нэмэгдэнэ гэсэн нь 3 нэгжээр өссөн бол үнэ өснө, бизнесийн орлого буурна, ажилгүй болно гэсэн хариултауд 3-5 нэгжээр буурсан дүнтэй байна.

ДҮГНЭЛТ

Санал асуулгын дүнгээр иргэдийн дийлэнхи нь /78%/ нь ирэх жилийн хугацаанд үнийн түвшинг ерөнхийдөө өснө гэж хүлээж байгаа бөгөөд харин ердөө 2% нь буурна гэжээ. Эдгээр чанарын хариултаудыг тоон утгад хөрвүүлбэл жилийн дараах иргэдийн хүлээлт 12%-д хүрч, өнөөдрийн инфляцийн түвшингээс өснө гэж үзжээ.

Энэ удаагийн санал асуулгад иргэдийн хүлээлтийг тодорхой тоон интервал өгөн асуусан бөгөөд уг асуултын дүнгээр иргэдийн хүлээлт нь хэвийн тархалттай байгааг батлан харуулсан. Бусад асуултаудын дүнгээр иргэдийн ихэнх нь ирэх 12 сард зээлийн хүү өсөх буюу хэвэндээ байна, төгрөгийн ханш чангарна, мөн хадгаламжинд мөнгөө байршуулахад хараахан тохиромжтой үе биш хэмээн үзсэн хэвээр байна. Харин тэдний өрхийн талаар асуухад сайжирна, муудна гэсэн хариултын хувь хэвэндээ гэсэн хариултын хэмжээ зонхилох хувийг эзэлж байлаа.